

“Зоос гоёл ХК”

2017 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн тайлангийн хугацаанд бүрэн бүрэлдхүүнээрээ компанийн дүрэм, бусад хууль журмаар олгосон эрхийн хүрээнд өөрсдийн хариуцсан үүрэг чиглэлийн дагуу ажиллаа. Тайлангийн хугацаанд их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.

Компани тайлант хугацаанд өмнөх онуудын адил өөрийн байрыг оффис, үйлчилгээний зориулалтаар ашиглуулах түрээслэгч аж ахуй нэгж, хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр түрээсийн үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ ерөнхийлөгчийн тамгын газрын захиалгаар төрийн одон медалиудыг харилцагч үйлдвэртэйгээ хамтран үйлдвэрлэн нийлүүлж ирсэн.

Компани орон тооны 18 ажилтнаас гадна ажлын шаардлагаар орон тооны бус ажилтнуудыг түр гэрээ байгуулан үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд үндсэн үйл ажиллагаанаас түрээсийн байрны урсгал засвар, өргөтгөлийн дээвэр, ханын дулаалга зэрэг засварын ажлуудыг хийхээс гадна ажилчдын ажлын байран дах хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хамгаалах, ажилчдын өдөр тутмын ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар тодорхой ажлуудыг үе шаттай зохион байгуулж захиргаа, санхүү, борлуулалт, маркетинг, аж ахуйн үйлчилгээний алба гэсэн зохион байгуулалттайгаар ажил үүргээ гүйцэтгэн ажиллаж байна. Компани санхүүгийн тайлан балансыг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртөгийн албан татвар, нийгмийн даатгалын тайланг хуульд заасан хугацаанд хүргүүлэн, холбогдох татваруудыг цаг тухайд нь төлж ажиллаж байна.

“Зоос гоёл” хувьцаат компанийн ХЭ-чдийн ээлжит 22-р хурлыг 2017.04.29-ний өдөр хуралдуулж, 2016 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, ногдол ашиг болон бусад хурлаар хэлэлцэх асуудлуудын хүрээнд тогтоол шийдвэрүүдийг хэлэлцэн баталсан. Тус хуралд оролцсон ХЭ-дийн саналаар дэмжигдэн батлагдсан гол хэлэлцүүлэг нь Зоос гоёл хувьцаат компанийн хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулах төсөл байсан бөгөөд ТУЗ-өөс төслийн хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зөвшөөрөл олгохыг хүссэн албан хүсэлтийг харьяа байгууллагуудад хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Мөн түүнчлэн компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулахтай холбогдон үүссэн хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны зах зээлийн үнийг тодорхойлох болон компанийн нийт хөрөнгийг дахин үнэлүүлэх зорилгоор СЗХ-оос зөвшөөрөлтэй хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох “Оюу Эрдэм Аудит” ХХК-аар “Компанийн хөрөнгийн болон бизнес үнэлгээ” –г гаргуулсан.

Компанийн 2017 оны 2-р улирлын санхүүгийн тайлан /хүснэгт №1/-с харахад нийт хөрөнгийн хэмжээ 2203,7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 309,7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлттэй шууд хамааралтай болно.

Харин эргэлтийн хөрөнгийн дүн 113,7 сая төгрөгөөр нэмэгдэж, түргэн хөрвөх хөрөнгийн хувийн жин өссөн эерэг өөрчлөлт гарчээ.

ЗООС ГОЁЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ (2016 оны мөн үетэй харьцуулснаар)						
/i yi ääi ö' äpегөөр/						
Үзүүлэлт / Тайлант хугацаа	2016.06.30		2017.06.30		Өөрчлөлт	
	үнийн дүн	х.жин	үнийн дүн	х.жин	үнийн дүн	х.жин
А. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН						
Эргэлтийн хөрөнгө	417,973.60	22.1	531,717.82	24.1	113,744.22	2.1
Үндсэн хөрөнгө-цэвэр	1,476,068.70	77.9	1,672,075.70	75.9	196,007.00	(2.1)
Нийт хөрөнгө	1,894,042.30	100.0	2,203,793.52	100.0	309,751.22	-
Өр төлбөр						
Богино хугацаат өмөг	77,143.60	4.1	238,357.89	10.8	161,214.29	6.7
Өр төлбөрийн дүн	77,143.60	4.1	238,357.89	10.8	161,214.29	6.7
Эзэмшигчдийн өмч						
Хувьцаат капитал	375,494.40	19.8	375,494.40	17.0	-	(2.8)
-Халаасны хувьцаа	(106,848.00)	(5.6)	(106,675.20)	(4.8)	172.80	0.8
Нэмж төлөгдсөн капитал	1,130,815.20	59.7	1,206,675.70	54.8	75,860.50	(4.9)
Хуримтлагдсан ашиг	417,437.10	22.0	489,940.73	22.2	72,503.63	0.2
-Тайлангийн үеийн	71,026.40	3.7	92,020.60	4.2	20,994.20	0.4
Өмнөх үеийн	346,410.70	18.3	397,920.13	18.1	51,509.43	(0.2)
Эзэмшигчдийн өмчийн дүн	1,816,898.70	95.9	1,965,435.63	89.2	148,536.93	(6.7)
Өр төлбөр ба өмчийн дүн	1,894,042.30	100.0	2,203,793.52	100.0	309,751.22	
Б. ОРЛОГЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН						
Борлуулалтын орлого	166,519.09	100.0	352,249.30	100.0	185,730.21	-
Борлуулсан бүтээгдхүүний өртөг	127,125.30	76.3	257,041.88	73.0	129,916.58	(3.4)
Нийт ашиг	39,393.79	23.7	95,207.42	27.0	55,813.63	3.4
Түрээсийн орлого	280,426.83	100.0	299,341.80	100.0	18,914.97	-
Үйл ажиллагааны зардал	274,088.96	97.7	313,639.03	104.8	39,550.07	7.0
Үйл ажиллагааны ашиг	45,731.66	2.3	80,910.19	(4.8)	35,178.53	(7.0)
Үйл ажиллагааны бус орлого	35,833.65	100.0	29,920.08	100.0	(5,913.57)	-
Үйл ажиллагааны бус зардал	598.07	1.7	7,916.38	26.5	7,318.31	24.8
Ердийн ажиллагааны аэ ёй	80,967.24	98.3	102,913.89	73.5	21,946.65	(24.8)
Орлогын татвараас өмнөх аэ ёй	80,967.24	16.8	102,913.89	15.1	21,946.65	(1.7)
Орлогын албан татварын зардал	9,940.86	2.1	10,893.30	1.6	952.44	(0.5)
Цэвэр ашиг	71,026.38	14.7	92,020.59	13.5	20,994.21	(1.2)
Нэгж хувьцаанд оногдох ашиг	5.45		7.06		1.61	
В. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН						
Хувьцаат капитал	268,646.40		268,819.20		172.80	
Нэмж төлөгдсөн капитал	1,130,815.25		1,206,675.69		75,860.44	
Хуримтлагдсан ашиг	417,437.07		489,940.73		72,503.66	
2013 оны 12 дугаар сарын 31-ны үлдэгдэл	1,816,898.72		1,965,435.62		148,536.90	
Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН						
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	30,082.27		141,656.46		111,574.19	
ХО-ын цэвэр мөнгөн гүйлгээ	12,847.30		(9,756.58)		(22,603.88)	
Санхүүгийн ү/а-ны цэвэр мөнгөн гүйлгээ	(120,681.82)		(283,384.70)		(162,702.88)	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(77,752.25)		(151,484.82)		(73,732.57)	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	351,427.75		368,997.54		17,569.79	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	273,675.51		217,512.73		(56,162.78)	

Компанийн ХЭ-дийн ээлжит 22-р хурлын №03 тоот тогтоолоор 2016 оны цэвэр ашиг 107,51 сая төгрөгөөс компанийн нийт зарласан 13,038 ширхэг энгийн /2015 онд хувьцааг нэгтгэсэнээр бий болсон/ хувьцаанаас компанийн халаасны 3,704 ширхэг хувьцааг хасч нийт гаргасан **9,334** /10,038-3,704/ ширхэг хувьцаанд нэгж хувьцаанд **6,000** төгрөгийн ногдол ашиг, нийт 56.0 сая төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд СЗХ-ноос ногдол ашиг олголт, тараах талаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2016 оны болон өмнөх онуудын он дамжсан ногдол ашгийн үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн ҮЦТХТ-дахь дансанд нь байршуулах, ногдол ашиг олголтын тооцоо судалгааг гаргаж, ҮЦТХТ ХХК-тай гэрээ байгуулаад хамтран ажиллаж байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаа орлого, зардлын талаар



Тус компанийн 2017 оны хагас жилийн үндсэн ажиллагааны нийт орлого гүйцэтгэлээр 681.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 198,6 сая /41,14%/ төгрөгөөр өссөн. Үндсэн үйл ажиллагааны орлогын 51.7 хувийг одон медалын борлуулалт, 43.9 хувийг түрээсийн орлого, 4.4 хувийг бусад орлого тус бүр эзэлж байгаа бөгөөд орлогын өсөлтийн дийлэнхийг буюу 90 гаруй хувийг одон медалийн борлуулалтын өсөлт хангасан байна. Тайлант хугацааны орлого, зардлын өсөлт бууралт, бүтцийг өнгөрсөн онтой харьцуулан доорх хүснэгт, графикаар харуулав.

Орлогын харьцуулалт /2016,2017 оны хагас жилээр/

Орлого	2016 II-р улирал		2017 II-р улирал		Өөрчлөлт	
	сая.төг	Эзлэх %	сая.төг	Эзлэх %	сая.төг	%
Одон медал борлуулалт	166,5	34,5%	352,2	51,7%	185,7	93,5%
Түрээсийн орлого	280,4	58,1%	299,3	43,9%	18,9	9,5%
Бусад	35,8	7,4%	29,8	4,4%	-6,0	-3,0%
НИЙТ ОРЛОГО	482,7	100%	681,3	100%	198,6	100%

Зардлын харьцуулалт /2016,2017 оны хагас жилээр/

	Зардал	2016 II-р улирал		2017 II-р улирал		Өөрчлөлт		
		сая.төг	Эзлэх %	сая.төг	Эзлэх %	сая.төг	%	
1	Өртөг	127,1	31,6%	257,1	44,5%	130	73,6%	
2	Үйл ажиллагааны зардал	Цалин, НДШ	137,1	34,1%	159,2	27,5%	22,1	12,5%
		Элэгдэл	69,5	17,3%	62,3	10,8%	- 7,2	-4,1%
		Ашиглалт	38,8	9,7%	64,0	5,9%	- 4,8	-2,7%
		Бусад	29,3	7,3%	35,8	11,4%	36,5	20,7%
	НИЙТ ЗАРДАЛ	401,8	100%	578,4	100%	205,9	100%	



2017 оны эхний хагас жилд үндсэн үйл ажиллагаанаас 651,5 сая төгрөгийн орлого бүрдүүлсний 54,1 хувийг бүтээгдэхүүний /одон медалийн/ борлуулалтаас, 45,9 хувийг түрээсийн төлбөрөөс, үйл ажиллагааны бус /эрхийн шимтгэлийн/ орлогоос 29,8 сая төгрөг нийт 681,3 сая төгрөгийн орлого олоход нийт 578,4 сая төгрөгийн зардал гаргасан нь 1 төгрөгийн борлуулалтын орлогод 85 мөнгө зарснаар орлогын төгрөг тутмаас 15 мөнгөний ашиг олж татварын өмнөх ашиг нийт 102,9 сая төгрөг болжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 22,0 сая төгрөгөөр өссөн хэдий ч орлого төгрөг тутмаас олох ашиг 2 мөнгөөр буурсан, өөрөөр хэлбэл 1 төгрөгийн орлогод ногдох зардал 2 мөнгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийг өртөг, зардлын бүтцээр задлан харвал борлуулсан бүтээгдхүүний өртөг 3 мөнгөөр буурч, үйл ажиллагааны /түрээсийн болон бусад/ орлогод ногдох зардал 11 мөнгөөр /үүнд цалин 5 мөнгөөр, ашиглалтын болон бусад зардал 6 мөнгөөр/ өссөнөөс болсон байна. Үйл ажиллагааны зардлын бүтцийг өнгөрсөн онтой харьцуулан графикаар харуулбал:

